

## **БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**Аудитын код: САГ-2018/119/СТА-ТӨҮГ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885

Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Аудитор Н.Золзаяа

Утас: 261740

Цахим хаяг: [zolzayan@audit.gov.mn](mailto:zolzayan@audit.gov.mn)

Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн захирал Г.Энхмаа

Утас: 99040059 450279

Цахим хаяг: [Enkhmaa\\_56@yahoo.com](mailto:Enkhmaa_56@yahoo.com)

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг

Утас: 99073014

Цахим хаяг: [oyuntsetsegl@yahoo.com](mailto:oyuntsetsegl@yahoo.com)

Аудитор Н.Уранчимэг

Утас: 91093898

Цахим хаяг: [urnaа\\_mhg@yahoo.com](mailto:urnaа_mhg@yahoo.com)

Улаанбаатар хот




## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	1
2	аудитын тайлан.....	3
2.1	Оршил .....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
2.5	Дотоод хяналт .....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар .....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
2.9.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд .....	7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал.....	9
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар .....	10
3.2	Авлага, өглөгийн талаар .....	11
3.3	Санхүүгийн тайлангийн талаар .....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлынтайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР</b> 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30 E-mail: info@audit.gov.mn	<b>БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Э МӨНХНАРАН ТАНАА</b>
<u>2018.03.29</u> № <u>06/853</u> танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад /СТОУС/-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<small>1110.10.10.20@Bichig_KheregiYawsan_Bichig120180329SAG1.Docx</small>	
071492	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**


**Үүрэг, хариуцлага**

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0329SAG1.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 2 АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын /цаашид Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ гэх/ 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын захирал Э.Мөнхнаран танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн бараа материалыг бодит үнэ цэнээр тооцох, зөрүүтэй авлагыг залруулах, СТОУС-ын шинэчлэлийг хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан, аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-наас 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр

САГ-2018-/119/СТА-ТӨҮГ



төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Н.Уранчимэг, аудиторын туслах Д.Должидмаа нар гүйцэтгэж, Чанарын хяналтын менежер Л.Оюунцэцэг хянаж ажиллалаа.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн 28 дугаар албан бичгээр “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Барилгын тухай, Барилга захиалагчийн дүрэм, болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажиллаж байна.

Батлан хамгаалах яамны сайдын 2009 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 293 дугаар тушаалаар Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ыг цэргийн тусгай объектын барилга байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт тавих, “Цэргийн орон сууц хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохицуулах зэрэг үйл ажиллагааны чиглэлтэй үүсгэн байгуулжээ.

#### **Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь :**

Батлан хамгаалах салбарт хэрэгжүүлж буй барилга угсралт, их засварын ажлуудад Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дүрэм, барилгын норм дүрэм, стандартыг мөрдүүлж гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад оршино. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнүүдийг хугацаанд нь чанарын өндөр түвшинд ашиглалтанд оруулах, тэдгээрийн гүйцэтгэлд бодит хяналтыг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах зорилготой гэжээ.

#### **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжилд нийцүүлэн бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг инженерүүдийн баг бүрдүүлж, барилга байгууламжийн нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд голлох үүрэг хүлээх зорилт тавьж байна.

#### **Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ өөрийн үйл ажиллагаандаа Батлан хамгаалахын сайдын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн А/200 тоот тушаалаар батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн дагуу барилгын иж бүрэн зураг төсөл боловсруулах, үе шатны ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлэх, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах ажлыг гүйцэтгэгч, ашиглагч, зураг төсөл боловсруулсан хуулийн этгээдүүдтэй хамтран хэрэгжүүлэх бодлого чиглэлийн дагуу ажиллана гэсэн байна.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдлага, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын багц хуулиудийг шалгуур болгон ашиглалаа.

Аудитаар Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан, түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Unicus" програм хангамжаар бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

## 2.6 Зорилтот түвшний талаарх тайлбар, тодруулга

Батлан хамгаалах яамны сайдын 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 2017 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогыг 318.5 сая төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 7.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 270.5 сая төгрөгөөр, татварын өмнөх ашгийг 15.1 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 13.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.


Тайлант оны гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 529.4 сая төгрөг, хүүгийн орлого 10.4 сая төгрөг, нийт 539.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 196.9 сая төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 274.3 сая төгрөг, бусад зардалд 21.8 сая төгрөг нийт 483.6 сая төгрөгийн зардал гаргаж, 7.2 сая төгрөгийн татварын зардалтай, 39.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад тухайн жилийн байгууллагын цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, 2017 оны орлого, зардлын гүйцэтгэл болон бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 чиглэлээр эрсдэлийг тооцож, батламжа мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим зорилт гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

## **2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

### **2.9.1 Мөнгөн хөрөнгийн талаар**

Кассын тайлангаас түүвэрлэн үзэхэд бараа материалын урьдчилгаанд 33.5 сая төгрөгийг нярвын нэрээр, анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийж хэвших талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

### **2.9.2 Авлага, өглөгийн талаар**

Тайлант онд нийт авлага, өглөг 63.3 сая төгрөгөөр буурсан ба урьдчилж төлсөн зардал тооцооноос үүссэн 37.5 сая төгрөг, бусад авлага, өглөгийн үлдэгдэл 95.5 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, он дамжсан, насжилт өндөртэй зарим өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Тайлант хугацааны 0.4 сая төгрөгийн утасны төлбөр буцааж тушаасан мөнгийг авлага, өглөгийн дансанд бүртгээгүй борлуулалтын орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацааны эцэст он дамжсан, насжилт өндөртэй авлага, өглөгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

### **2.9.3 Санхүүгийн тайлангийн талаар**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайлантай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журнал, санхүүгийн баримтыг 3 дугаар сарын 13-наас 17-ны өдрийн хооронд ирүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.12-т “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг энэ хуульд заасан эрх бүхий байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчиж байна.



Шийдвэрлэсэн нь: Хуулийн хугацаанд санхүүгийн тайланг бэлтгэж, шаардлагатай баримт бичгийн хамт ирүүлж хэвших талаар менежментийн захидлаар зөвлөмж, албан шаардлага өгөв.

## **2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Тус байгууллын удирдлага он дамжсан авлага, өглөгийг барагдуулах, холбогдох газраар шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

## **2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн үйл ажиллагааны орлого болох Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын орлого, ажил гүйцэтгэх гэрээний дагуу олгосон мөнгө, урьдчилж төлсөн зардал тооцоог нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 133.1 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 33.9 сая төгрөгийн материаллаг бус зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өглөө.

## **2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК аудит хийж, 3 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна.

## **2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын материаллаг байдлыг төлөвлөлтийн үе шатанд 2017 оны нийт орлогын 2 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр тодорхойлж баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төрийн өмчит байгууллагын хувьд хувь хэмжээг өндрөөр тогтоовол түүвэрт өртөх гүйлгээ их гарахаар байсан тул аль болох олон гүйлгээг хамруулах зорилгоор сонгосон. Гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцоолж үзэх шаардлагагүй гэж үзлээ.

## **2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.





**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ БАРИЛГА  
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА ТӨААТҮГ-Н 2017 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:**

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар.....8

Асуудал 2

Авлага, өглөгийн талаар.....9

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

Асуудал 3

Санхүүгийн тайлангийн талаар.....10

**2018 оны 3 дугаар сар**



### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**3.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Кассын тайлангаас түүвэрлэн үзэхэд бараа материалын урьдчилгаанд 33.5 сая төгрөгийг нярвын нэрээр, анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчиж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Цаашид холбогдох хуулийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийж хэвших.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал, иж бүрэн байх, тодруулга ба толилуулга, оршин байх эдгээр батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.2 Авлага, өглөгийн талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №1**

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант хугацааны 0.4 сая төгрөгийн утасны төлбөр буцааж тушаасан мөнгийг авлага, өглөгийн дансанд бүртгээгүй борлуулалтын орлогоор бүртгэсэн, он дамжсан, насжилт өндөртэй зарим өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Цаашид авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, авлага өглөгийн насжилтийг тогтоож, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг зөвлөж байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, тодруулга ба толилуулга, иж бүрэн байх эдгээр батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

**Байгууллагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



<b>3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №2</b>	
---	----------------------------------	--

**ҮАГ-ын ажиглалт**

Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ -нь 2017 оны санхүүгийн тайлантай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журнал, санхүүгийн баримтыг 3 дугаар сарын 13-17-ны хооронд ирүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.12-т “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг энэ хуульд заасан эрх бүхий байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасныг зөрчиж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Цаашид холбогдох хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх

**Эрсдэлүүд**

Холбогдох хууль тогтоомж зөрчих эрсдэлтэй.

**Байгууллагын хариу**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.




#### 4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

##### 4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫНТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	151,134,492.99	286,224,204.57
1.1.2	Дансны авлага	146,829,684.05	87,425,476.05
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	160,509,397.12	156,588,397.12
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	57,709,408.00	37,381,814.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	96,691,629.92	134,526,629.92
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>612,874,612.08</b>	<b>702,146,522.16</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	113,252,732.57	89,976,043.53
1.2.2	Биет бус хөрөнгө	3,502,233.45	1,673,666.82
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>116,754,966.02</b>	<b>91,649,710.35</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>729,629,578.10</b>	<b>793,796,232.51</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	133,170,295.00	137,228,305.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	3,580,657.19	19,513,544.88
2.1.1.4	НДШ-ийн өглөг	201,184.78	2,328,744.05



2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,665,000.34	
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	205,057,951.43	210,734,855.43
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>344,675,088.74</b>	<b>369,805,449.36</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>344,675,088.74</b>	<b>369,805,449.36</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : - төрийн	125,043,641.34	125,043,641.34
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	24,496,368.57	24,496,368.57
2.3.9	Хуримтлагдсан ашиг	235,414,479.45	274,450,773.24
2.3.10	Тайлант үеийн ашиг	-	39,526,293.79
	Өмнөх үеийн ашиг	-	234,924,479.45
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>384,954,489.36</b>	<b>423,990,783.15</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>729,629,578.10</b>	<b>793,796,232.51</b>





**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>2016.12.31</b>	<b>2017 оны 12-р сарын 31</b>
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>416,855,032.69</b>	<b>529,402,665.33</b>
2	Борлуулалтын өртөг	60,116,441.00	196,836,285.00
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>356,738,591.69</b>	<b>332,566,380.33</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		10,442,049.80
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
	Орлогын дүн		<b>539,844,715.13</b>
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	202,969,035.86	274,387,056.28
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	297,042.09	(35,963.09)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(6,445,860.67)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(15,351,500.00)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>154,066,597.92</b>	<b>46,788,050.09</b>
19	Орлогын татварын зардал	15,406,659.79	7,261,756.30
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>138,659,938.13</b>	<b>39,526,293.79</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>138,659,938.13</b>	<b>39,526,293.79</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>-</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>138,659,938.13</b>	<b>39,526,293.79</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	125,043,641.34		24,496,368.57	235,414,479.45	384,954,489.36
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	125,043,641.34		24,496,368.57	235,414,479.45	384,954,489.36
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-			-
9	<b>2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	125,043,641.34	-	24,496,368.57	235,414,479.45	384,954,489.36
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-			(490,000.00)	(490,000.00)
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>					-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				39,526,293.79	39,526,293.79
13	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	125,043,641.34	-	24,496,368.57	274,450,773.24	423,990,783.15


01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>692,189,271.45</b>	<b>1,036,668,883.03</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	151,974,149.06	553,430,732.64
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	310,527,200.00	7,697,000.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	229,687,922.39	475,541,150.39
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>782,861,065.46</b>	<b>911,985,058.16</b>
	Ажиллагчдад төлсөн	105,221,633.62	90,155,983.09
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,722,644.30	9,773,476.89
	Бараа материал худалдан авахад төлсөн	12,806,235.03	35,019,112.00
	Ашиглалтын зардалд төлсөн	67,473,708.07	181,487,233.44
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,373,973.00	17,762,535.00
	Хүүний төлбөрт төлсөн	13,405,693.69	7,585,500.09
	Татварын байгууллагад төлсөн		
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	560,857,177.75	570,201,217.65
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(90,671,794.01)</b>	<b>124,683,824.87</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>12,901,680.01</b>	<b>10,442,049.80</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	12,901,680.01	10,442,049.80
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>5,580,000.00</b>	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,580,000.00	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		



	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
	Бусад		
<b>2.</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>7,321,680.01</b>	<b>10,442,049.80</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.	Мөнгөн орлогын дүн (+)	336,634.64	49,010.29
1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад	336,634.64	49,010.29
3.	Мөнгөн зарлагын дүн (-)	39,592.55	<b>84,973.38</b>
2	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад	39,592.55	84,973.38
<b>3.</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>297,042.09</b>	<b>(35,963.09)</b>
<b>3</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(83,053,071.91)</b>	<b>135,089,911.58</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>234,187,564.90</b>	<b>151,134,492.99</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>151,134,492.99</b>	<b>286,224,204.57</b>
<b>6</b>			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 03 дугаар сарын 29

№ 03/101

САГ-2018/119/СТА-ТӨҮГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ /цаашид Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ гэх/-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлан хамгаалах яамны Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайлантай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журнал, санхүүгийн баримтыг 3 дугаар сарын 13-17-ны хооронд ирүүлсэнтэй холбоотойгоор аудит хийсэн тайлангийн хугацаа хоцроосон нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 03 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15-р зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайлан, холбогдох нягтлан бодох бүртгэлийн журнал, бусад шаардлагатай баримт, материалыг хуульд заасан хугацаанд нь ирүүлж байх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Батлан хамгаалах яамны "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын дарга Э.Мөнхнаран, ерөнхий нягтлан бодогч А.Дорж нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

<p><b>ӨГСӨН:</b>          САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН          ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ          АУДИТОР <i>[Signature]</i> Д.НАРАНЧИМЭГ          АУДИТОР <i>[Signature]</i> Н.ЗОЛЗАЯА  <b>ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:</b>          "АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙН АУДИТ" ХХК-ИЙН          АУДИТОР <i>[Signature]</i> Н.УРАНЧИМЭГ</p>	<p><b>ЗӨВШӨӨРСӨН:</b>          БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЛБА          ТӨААТҮГ-ЫН ДАРГА  <i>[Signature]</i> Э.МӨНХНАРАН          ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ  <i>[Signature]</i> А.ДОРЖ</p>
---	--

Акт, албан шаардлагын биелэлт хангасдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагын зөрчсөн албан шаардлагыг биелүүлэх ажлыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг 12 сарын ажлын нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулах" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлэх.

110.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2018\03\101\03\101\119\СТА-ТӨҮГ\0318075

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ